



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан¹)

ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС ХЭРЭГСЛИЙГ ӨМСӨХ, СОЛИХОД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛБАЙ РУУ ИРЖ, ОЧИХ ХУГАЦААГ АЖИЛСАН ЦАГТ ОРУУЛАН ТООЦНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн нэр: IBP, Inc. v. Alvarez, 546 U.S. 21 (2005)

Шүүхийн шийдвэрийн огноо: 2005 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

IBP компанийн мах боловсруулах үйлдвэрийн ажилчид нь малгай, бээлий, хормогч, гутал зэрэг хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсөх шаардлагатай байдаг бөгөөд тухайн үйлдвэрийн ажилчид энэхүү хамгаалалтын хэрэгслийг өмсөх, тайлахад зарцуулсан хугацаа, мөн хувцас солих өрөө болон үйлдвэрлэлийн талбайн хооронд алхсан хугацааг ажилсан цагт тооцуулж, цалин гаргуулахыг хүсэж шүүхэд нэхэмжлэл гаргасан. Харин хариуцагч компанийн зүгээс хамгаалалтын хувцас, хэрэгсэл өмсөх нь ажилчдын “үндсэн үйл ажиллагаа” биш тул ажлын цагт тооцож, цалин олгох үндэслэлгүй хэмээн маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Дүүргийн шүүхээс:** Хамгаалалтын хувцас хэрэгслийг өмсөж, тайлахад зарцуулсан хугацаа, хувцас солих өрөө болон үйлдвэрлэлийн талбай хооронд алхах хугацааг ажилсан цагт тооцож, цалин олгох нь зүйтэй гэж үзсэн.
- 2. Давж заалдах шатны есдүгээр шүүхээс:** Дүүргийн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, дээрх үйл ажиллагаа нь ажилчдын үндсэн ажлын үйл ажиллагаатай салшгүй холбоотой бөгөөд ажилчид үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тул Шударга хөдөлмөрийн стандартын тухай хууль (Fair Labor Standards Act)²-ийн дагуу “ажлын цаг”-т хамаарна гэж дүгнэсэн.
- 3. Дээд шүүхээс:** Ажилтан үндсэн үүргээ гүйцэтгэхэд салшгүй холбоотой болон зайлшгүй шаардлагатай аливаа үйл ажиллагаа нь ажилтны гүйцэтгэх “үндсэн үйл ажиллагаа”-д хамаарах ёстой гэдгийг шүүх тодруулж, эдгээр үйл ажиллагаанд зарцуулсан цагийг ажлын цагт тооцно

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

[IBP, Inc. v. Alvarez :: 546 U.S. 21 \(2005\) :: Justia US Supreme Court Center](#)

² Fair Labor Standards Act (1938)

<https://www.dol.gov/sites/dolgov/files/WHD/legacy/files/FairLaborStandAct.pdf>



гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хэрэгт ажилчдын зайлшгүй шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэглэлийг өмсөж, тайлахад зарцуулсан хугацаа нь “ажлын цаг”-т багтах ёстой тул цалинтай байх ёстой гэж тайлбарласан байна.

4. АНУ-ын Засгийн газрын Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга (Secretary of Labor)-ын 2005 онд баталсан журмын 29 CFR §790.7(h)³-д "ажил олгогч нь ажилтныг ажлын байран дээрээ эсвэл үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг өөр газартаа байгаа цагийг тайлагнахыг шаарддаг бол ажилтан тухайн газар, цагт ажиллахад бэлэн байгаа боловч ажилтнаас үл хамаарах шалтгаанаар хийх ажил байхгүй, ажлаа хүлээх нь ажилтны үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг байх болно" гэж зохицуулсан байдаг нь нэхэмжлэгчийн хүсэл зоригтой нийцнэ гэж дүгнэжээ.
5. Мөн тухайн шийдвэрээр ажилтнуудын хувцас солих өрөө болон үйлдвэрийн байр хооронд алхах хугацааг Шударга хөдөлмөрийн стандартын тухай хууль (Fair Labor Standards Act)-ийн дагуу “ажлын цаг”-т хамаарна гэж үзэхдээ “ажлын өдрийн тасралтгүй байх дүрэм”-ийг баримталсан байна.
6. Хариуцагч талаас Ажлын цагийн тухай хууль (Portal-to-Portal Act)⁴-ийн дагуу үндсэн үйл ажиллагаа явуулах газар руу зорчих зэрэг үйл ажиллагаа нь цалингүй байх ёстой гэж маргасан боловч шүүхээс ажлын цаг эхэлснээс хойш эсвэл дуусахаас өмнөх хугацаа хамаарахгүй тул ажлын хувцас, хэрэглэл өмссөнөөс тайлах хүртэл хугацаанд үйлдвэрийн байр болон ажилтны хувцас солих өрөө хооронд алхахад зарцуулж буй хугацаа нь “ажлын цаг”-т багтана гэж үзсэн буюу цалинтай байх ёстой гэж үзжээ.

---o0o---

³Electronic Code of Federal Regulations (e-CFR) §790.7(h) - <https://www.law.cornell.edu/cfr/text/29/790.7>

⁴ Portal-to-Portal Act (1947) [29 USC Ch. 9: PORTAL-TO-PORTAL PAY \(house.gov\)](https://www.house.gov/legislation/record/29 USC Ch. 9: PORTAL-TO-PORTAL PAY)

Энэхүү хууль нь ажилтны ямар төрлийн үйл ажиллагааг ажилласан цагт тооцох талаар зохицуулсан байдаг. Тухайлбал, өдөр тутмын ажлын байрандаа ирэх, буцах хугацаа болон үндсэн үйл ажиллагаанаас өмнө эсвэл дараа хийгддэг хувцас солих, гар угаах гэх мэт үйл ажиллагааг ажилласан цагт тооцдоггүй. Гэхдээ эдгээр үйл ажиллагаа нь ажилтны үндсэн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бол тооцно. Жишээлбэл, ажлын онцлогоос шалтгаалан хамгаалалтын хувцас, хэрэглэл өмсөхөд зарцуулсан хугацааг ажилласан цагт оруулан тооцохоор зохицуулсан байдаг.